

**Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний
хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн,
Эрүүл мэндийн яам, 2025 оны эхний хагас жилийн байдлаар**

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дүгээр тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлагдсан.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний Бүсчилсэн хөгжлийн бодлогын орон нутгийн эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлнэ Зорилго 2-ын хүрээнд Эрүүл мэндийн яам үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар нийт 1, Хүний хөгжлийн бодлогын өвчлөл, нас баралтыг бууруулна Зорилго 3-ын хүрээнд Эрүүл мэндийн яам үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар нийт 22 арга хэмжээ тусгагдсан байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ тус бүрийн хүрсэн түвшинг тодорхойлох, хүлээгдэж буй үр дүндээ хүрэх боломжтой эсэхийг нягтлах, арга хэмжээг эрчимжүүлэх санал, зөвлөмжийг боловсруулах, шийдвэр гаргагч нарыг мэдээллээр хангах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэсэн болно.

Хоёр. Хяналт-шинжилгээ үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу хяналт-шинжилгээг хийж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг журмын нэгдүгээр хавсралтын 6.1, 6.5 дугаар заалтад заагдсан бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлэх аргачлалыг баримтлан арга хэмжээний хэрэгжилтийн хувиар тооцон гаргасан.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан эрүүл мэндийн салбарын 23 арга хэмжээний хэрэгжилт 2025 оны эхний хагас жилийн байдлаар 48 хувьтай үнэлэгдсэн.

“Үр дүнтэй” буюу 85 хувь буюу түүнээс дээш үнэлгээтэй 8 арга хэмжээ;

1. 3.1.2.1.Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад алсын зайн анагаах ухаан (телемедицин)-ыг хөгжүүлэх (СТГ);

2. 3.1.2.2.Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төвийг барих (СЭЗБГ);

3. 3.1.2.4."Халдварт өвчин судлалын үндэсний төв II"-ыг барих (СЭЗБГ);

4. 3.1.2.6.Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын чадавхыг бэхжүүлэн төвлөрлийг сааруулах (СЭЗБГ);

5. 3.1.2.7.Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1, 2 дугаар үе шатны төслийг хэрэгжүүлэх (СЭЗБГ);

6. 3.1.2.10.Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээ байгуулах төслийг хэрэгжүүлэх (СЭЗБГ);

7. 3.1.4.1.Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж үйлчилгээний өртөг, төлбөрийн аргыг боловсронгуй болгох (СЭЗБГ);
8. 3.1.5.1.Эрүүл мэндийн салбарын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх (СТГ).

“Үр дүн хүлээгдэж байгаа” буюу 60-84 хувийн үнэлгээтэй 3 арга хэмжээ;

1. 3.1.1.1 Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэний тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах, эрт илрүүлэх, үзлэг, оношилгоог эрчимжүүлэх (НЭМБГ);
2. 3.1.2.12.Монгол Улсын Зүрх Судлал, Зүрхний мэс засал ба Телемедицин төслийг хэрэгжүүлэх (ЭТБГ);
3. 3.1.3.1.Олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакцины худалдан авалтад төрийн оролцоог идэвхжүүлэх (СТГ).

“Үр дүн хангалтгүй” буюу 30-59 хувийн үнэлгээтэй 2 арга хэмжээ байна. Үүнд:

1. 3.1.1.1 Эрүүл шүд арга хэмжээний (2024-2027) тухайн оны төлөвлөгөөт арга хэмжээний хэрэгжилт (НЭМБГ);
2. 3.1.2.5 Бүсүүдэд лавлагаа шатлалын эмнэлэг барих төслийн бэлэн байдлыг хангаж, эхлүүлэх (СЭЗБГ).

“Үр дүн гараагүй” буюу 0-29 хувийн үнэлгээтэй 10 арга хэмжээ байна. Үүнд:

1. 2.1.1.7. Дархан-Уул аймагт бүсийн нэгдсэн эмнэлэг байгуулах (СЭЗБГ);
2. 3.1.1.1 "Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх", "Эрүүл Монгол", "Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийн цогц арга хэмжээний тухайн оны төлөвлөгөөт арга хэмжээний хэрэгжилт (НЭМБГ);
3. 3.1.2.3.Зүрх, судасны үндэсний төвийг барих (СЭЗБГ);
4. 3.1.2.8.Монгол Улсад оношлогдох, эмчлэгдэх боломжгүй өвчний чиглэлээр технологи нэвтрүүлэх (ЭТБГ);
5. 3.1.2.9.Эрүүл мэндийн байгууллагуудын автомашины парк шинэчлэлтийг хийх (СЭЗБГ);
6. 3.1.2.11.Эрүүл мэндийн системийн тархалтын хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх төслийг хэрэгжүүлэх (НЭМБГ);
7. 3.1.2.13.Улаанбаатар хотод 2 дугаар шатны эрүүл мэндийн төвийг барих (СЭЗБГ);
8. 3.1.3.2.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын хяналтын лавлагаа лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх (СТГ);
9. 3.1.3.3.Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, чанар, аюулгүй байдлын нэгдсэн цахим тогтолцоо нэвтрүүлж, эмийн мэдээллийн ил тод байдлыг хангах (СТГ);
10. 3.1.5.2.Эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах (СТГ).

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлийн 19 арга хэмжээний хэрэгжилт 2025 оны эхний хагас жилийн байдлаар 31.6 хувьтай үнэлэгдсэн.

“Үр дүн хүлээгдэж байгаа” буюу 60-84 хувийн үнэлгээтэй 3 арга хэмжээ;

1. 3.3.4.Эмийн импортын мэдээллийг цахимжуулах, эмийн жагсаалтыг шинэчлэх, олон улсын стандартыг бүрэн нэвтрүүлэх, гадаад улс орноос эм, эмнэлгийн хэрэгслийн шууд болон дамжуулан худалдан авалт хийх тогтолцоог бүрдүүлнэ (СТГ);

2. 3.3.11.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, орон нутгийн нэгдсэн эмнэлгийн чадавхыг бэхжүүлж, зарим тусламж, үйлчилгээний төвүүдийг төрөлжүүлэн байгуулна /Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв, Хавдар судлалын үндэсний төв-II, Халдварт өвчин судлалын үндэсний төв-II, Зүрх судасны үндэсний төв (ЭТБГ, СЭЗБГ);

3. 3.3.14.Уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж, уламжлалт эмийн үйлдвэрлэлийг олон улсын түвшинд хүргэн, экспортод гарах гарцыг нэмэгдүүлнэ (СТГ).

“Үр дүн хангалтгүй” буюу 30-59 хувийн үнэлгээтэй 8 арга хэмжээ байна. Үүнд:

1. 3.3.1.Эрүүл, идэвхтэй амьдралын зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэх бодлогын реформыг хэрэгжүүлнэ (НЭМБГ);
2. 3.3.2. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийг үргэлжлүүлж, хүн амыг өвчнөөс сэргийлэх, хянах хөтөлбөр хэрэгжүүлэн иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ (НЭМБГ);
3. 3.3.5. Эрүүл мэндийн салбарын чанар, үр дүнд суурилсан гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоог сайжруулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авахад иргэнд учрах санхүүгийн дарамтыг бууруулах, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг эхлүүлнэ (СЭЗБГ);
4. 3.3.7. Сүрьеэ, зарим төрлийн бэлгийн замын халдварт өвчнийг хяналтад авах, устгах бодлого, төлөвлөгөө боловсруулан, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлнэ (НЭМБГ);
5. 3.3.8. Олон улсын жишгээр "Эрүүл сургууль", "Эрүүл цэцэрлэг" хөтөлбөрийг эцэг эх, асран хамгаалагчдын оролцоотой хамтран хэрэгжүүлж, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл хүүхэд сурч, хөгжих нөхцөл, боломжийг бүрдүүлэх стратеги, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ (НЭМБГ);
6. 3.3.9."Эрүүл шүд", "Хорт хавдраас сэргийлэх, хянах", зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх "Эрүүл Монгол" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ (НЭМБГ, ЭТБГ);
7. 3.3.10. Цахим эрүүл мэндийн үйлчилгээг нэгтгэн уялдуулж, үр ашгийг дээшлүүлнэ /Өвчний болон эмчилгээний түүх, эмчийн онош, жорын нэгдсэн өгөгдлийн систем/ (СТГ);

8. 3.3.13. Цөөн хийгддэг, өндөр зардалтай тусламж, үйлчилгээг гадаад улсын эмнэлэгтэй хамтын гэрээ байгуулж, тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлнэ (ЭТБГ);

“Үр дүн гараагүй” буюу 0-29 хувийн үнэлгээтэй 5 арга хэмжээ байна. Үүнд:

1. 3.3.3. Газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зориулалттай Хуримтлалын сангаас иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээнд зориулан дэмжлэг үзүүлэх, эрх зүйн орчныг бүрдүүлнэ (СЭЗБГ);
2. 3.3.6. Хүн амын дунд согтууруулах ундаа, тамхины хэрэглээг бууруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх, ажлын байрны дотоод орчин, олон нийтийн газар, нийтийн тээвэрт иргэд дам тамхидалтад өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж, Тамхины хяналтын тухай хуулийг шинэчлэн боловсруулна (НЭМБГ);
3. 3.3.12. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх тогтолцоог бэхжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ (ЭТБГ);
4. 3.3.16. Сэргээн засах тусламж, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдэд урт болон богино хугацаагаар, цогц байдлаар, нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээг үзүүлж, чанар, аюулгүй байдлыг хангана (ЭТБГ);
5. 4.7.11. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бүхий л үйл ажиллагааг төрийн хяналтад авч, уг үйл ажиллагааг зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлүүлэх, мансуурах донтой хүнд олон улсын стандартад нийцсэн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, мансуурах донг эрт илрүүлэх, эмчлэх, хяналтад авах, нийгэмшүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно (НЭМБГ).

Дөрөв. Дүгнэлт

1. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан эрүүл мэндийн салбарын 23 арга хэмжээний хэрэгжилт 2025 оны эхний хагас жилийн байдлаар 48 хувь буюу “Үр дүн хангалтгүй” гэсэн үнэлгээтэй байна.

2. 2025 оны эхний хагас жилийн байдлаар улсын төсвөөс 17 хүний гадаад эмчилгээний зардалд 908.423 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна.

3. “Үр дүн гараагүй” гэсэн үнэлгээтэй 15 арга хэмжээ 2025 оны жилийн эцэс гэхэд зорилтот түвшинд хүрэхгүй байх магадлалтай байна.

Тав. Зөвлөмж

Хөгжлийн төлөвлөгөөний арга хэмжээнээс “Үр дүн хангалтгүй”, “Үр дүн гараагүй” гэсэн 25 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтийн явцад хяналт тавих шаардлагатай байна.

Эрүүл мэндийн яам

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

2025 оны 6 дугаар сарын 30